

**1950-1965 ОНЫ МОНГОЛ-ХЯТАДЫН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ,
БУУРАЛТЫН ШАЛТГААН**

Н.АЛТАНТӨГС

Товч агуулга: Бид энэхүү өгүүллээр Монгол-Хятадын 1950-65 оны социалист худалдааны нийт эргэлт, экспорт, импортын хэмжээг БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны тайланд үндэслэн нягтлав. 1950, 1960-аад оны Монгол-Хятадын бүх талын харилцаа, түүний дотроос худалдааны харилцааны ерөнхий орчин нь Зөвлөлт-Хятадын улс төр, эдийн засгийн харилцаа байсан боловч зарим талаар Зөвлөлт-Хятадын харилцаанаас ялгарах онцлог шинжтэй байна. Монгол-Хятадын худалдаа хөгжингүй үедээ төмөр замын транзит тээврийн төлбөрт тулгуурласан, Монголын импорт давамгайлсан худалдаа байсан бол 1961-65 оны харилцааны бууралтын үед Зөвлөлт-Хятадын зөрчлөөс улбаатай гадаад худалдааны балансыг тэнцэтгэх Хятадын бодлого ба Хятадтай худалдааны харилцаагаа хэвээр хадгалахыг оролдсон Монголын талын эрмэлзлэл голлосон худалдаа байжээ.

Түлхүүр үг: Социалист блок, Монгол-Хятадын харилцаа, гадаад худалдаа, экспорт, импорт, транзит тээвэр

1. Судалгааны асуудал: Өсөлт, бууралтын хүчин зүйлс

Монгол улс бол Орос, Хятадын хооронд оршдог хөдөө аж ахуй, уул уурхай голлосон эдийн засагтай хөгжиж байгаа улс юм. Монгол улсын хөгжилд түүний хоёр их хөрш ОХУ, БНХАУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Үүнээс ялангуяа БНХАУ-тай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцаа нь Монгол улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл юм. Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа түүхийн хэд хэдэн үеийг туулан хөгжиж иржээ. Үүний дотроос 1949 онд БНМАУ, БНХАУ дипломат харилцаа тогтоосноос эхлэн 1965 онд хоёр улсын харилцаа зогсонги байдалд орох хүртэлх хугацааг Монгол-Хятадын харилцааны түүхийн нэгэн үе болгон авч үздэг.

Энэ үе нь Монгол-Хятадын харилцааны хөгжиж ирсэн түүхэн дэх олон талаар өвөрмөц онцлог бүхий нэгэн шат бөгөөд үүний гол онцлог бол 1950, 1960-аад он бол хоёр улсын харилцаа эдийн засгийн талаар огцом өсч, эргээд огцом унасан

үе юм. 1930 оноос хойш 1949 онд БНХАУ байгуулагдах хүртэл Монгол-Хятадын хооронд ямар нэгэн худалдаа хийгдээгүй байснаа 1950-52 онд алгуур сэргэж, 1960 он гэхэд 27 сая рубль болж өсчээ. Хятадтай худалдаа хөгжүүлсний үр дүнд БНМАУ-ын бараа, таваарын хангамж сайжирч, гурил, бөс даавуугаар гачигдахгүй болжээ. Гэвч 1961 оноос эхлэн тус хоёр улсын хооронд явагдах худалдаа огцом унаж, түүнээс хойш 1980-аад он хүртэл жил бүр ердөө нэг сая орчим рублийн худалдаа хийх болжээ. Хятадтай хийх худалдаа зогссоны улмаас 1960-аад оны эхний хагаст БНМАУ-д эдийн засгийн богино хугацааны хүндрэл үүсч, Зөвлөлтөөс их хэмжээний зээл, тусламжавч эхэлжээ. Зогсонги байдалд орсон Монгол-Хятадын харилцаа урьдын түвшиндээ очтол бараг 30 жилийг зарцуулав.

Энэхүү 15 жилийн доторх огцом хувиралт юунаас болов? Үүнд ямар хүчин зүйлс нөлөөлөв? Үүний гол сургамж нь юу вэ?

2. Эх сурвалж, судлагдсан байдал

1950-1965 оны Монгол-Хятадын худалдаанд шууд холбогдох гэрээ, хэлэлцээрүүдээс ихэнх нь монгол ба хятад хэлээрх ном, зохиолуудад нийтлэгджээ¹. Гэвч зарим чухал баримтууд өнөөг хүртэл судалгааны эргэлтэд ороогүй байгаа бөгөөд тухайлбал 1953 оны 2 сарын 24-нд байгуулсан Монгол-Хятадын Засгийн газар хоорондын худалдааны биш зээллэгийн хэлэлцээр, мөн оны 8 сарын 20-нд байгуулсан Монгол-Хятадын 1953 оны бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээрүүд болон Монгол-Хятадын жил тутмын харилцан бараа нийлүүлэх гэрээнүүд, түүний хавсралтууд бүгд нийтлэгдээгүй байна. Үүний дотроос ялангуяа жил тутмын харилцан бараа нийлүүлэх гэрээний хавсралтад заасан бараа, тус гэрээний жилийн эцсийн биелэлтийн тайлангууд бол хоёр улсын худалдаалсан бараа, бүтээгдэхүүн, түүний өөрчлөлтийг улс төрийн байдалтай уялдуулан тайлбарлах чухал мэдээллийг агуулж байдаг.

1990 оноос өмнө БНМАУ-ын статистик дүн мэдээнүүдэд Хятадтай хийсэн худалдааны экспорт, импортын ерөнхий тоо мэдээ буй боловч үүний жил бүрийн өөрчлөлтийг харуулсан дэлгэрэнгүй дүн мэдээ нийтлэгдээгүй байв. Харин Ч.Далай, И. Шима болон Л.Бэгзжав нарын бүтээлүүд дээрх тоо баримтыг багтаажээ.² Монгол-Хятадын худалдааны тоо баримтыг агуулсан чухал эх сурвалж

¹ 《中蒙关系45年（1949-1994）》。内蒙古科技印刷厂印刷。1998； Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран, Бээжин, 2009; Жоу Эньлай ба Монгол орон, Улаанбаатар: Архивын Ерөнхий Газар, 2014; Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд. Улаанбаатар. 2009.

² Далай, Ч., Шима И., *Монгол-Хятадын харилцаа* (1949-1980), Улаанбаатар-Прага, 1986; *Бэгзжав, Л. Монгол-Хятадын харилцаа* (1949-1999), Улаанбаатар, 1999.

болох БНМАУ-ын гадаад худалдааны дэлгэрэнгүй тайлангууд нь социализмын үед маш нууцын зэрэглэлтэй хадгалагдаж байсан ба 1990 оноос хойш тус баримтууд судлаачдад нээлттэй болов. Тус өгүүлэлд БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны БНХАУ-тай хийсэн худалдааны тайланг статистик тоо баримтын анхдагчэх сурвалж болгон авав.³ Үүний хамт Хятадад хэвлэгдсэн “Хятадын гадаад эдийн засаг, худалдааны жилийн тайлан: 1984” статистикийн эмхтгэлд 1949-1984 онд БНМАУ-тай хийсэн худалдааны тоо баримт бүрэн хэмжээгээр орсон⁴ ба үүнийг хоёр дахь үндсэн эх сурвалжаар тооцов.

Социализмын эхэн үеийн Монгол-Хятадын худалдааны өсөлт, огцом бууралтын шалтгааныг эрдэмтэн, судлаачид эн тэргүүн улс төрийн хүчин зүйлсээр тайлбарлаж иржээ. С. Шарад⁵, Р.Рупен⁶, О.Латтимор⁷, М.В.Мещеряков⁸, Т.А.Якимова⁹ болон бусад¹⁰ судлаачид Монгол-Хятадын харилцаа ба шинэ Хятад улсаас жижиг социалист орнуудад хандан явуулсан зээл, тусламжийн бодлогыг судлах хүрээнд Монгол-Хятадын харилцаа, түүний дотор худалдааны харилцааг тодорхой хэмжээнд хөндсөн бий.

Социализмын үеийн Монгол-Хятадын харилцааны түүхийг авч үзсэн эдгээр болон бусад судалгаануудын үр дүнд Монгол-Хятадын 1950-60-аад худалдааны ерөнхий зураглал бий болжээ. Гэвч урьд өмнөх судалгаанд 1950-60 онд Монгол-Хятадын худалдаа хэрхэн, ямар шалтгааны улмаас огцом өсөн нэмэгдсэн, 1961-62 онд яагаад Монголын экспорт эрчимтэй өссөн, тус хоёр улсын худалдаа эрс хорогдсон явдалд Зөвлөлтөөс үл хамаарах хүчин зүйл нөлөөлсөн эсэхэд хариулт өгөөгүй байна.

Бид энэхүү өгүүллээр 1-рт, Монгол-Хятадын худалдааны өсөлт, бууралт нь Зөвлөлт-Хятадын худалдаанаас юугаараа онцлог болох, 2-рт, Монгол-Хятадын худалдааны өсөлт, бууралт ямар хүчин зүйлээр нөхцөлдсөнийг тодруулахыг зорив.

³ МУҮТА, ф-38, д-1, хн-917.

⁴ 《中国对外经济贸易年鉴1984》，北京：中国对外经济贸易出版社，1984年

⁵ Sharad, S. K., *Mongolia-Russia Relations: Kiakhta to Vladivostok*, Delhi: Shipra Publications & Maulana Abul Kalam Azad Institute of Asian Studies, 2002;

⁶ Rupen, R., *How Mongolia Is Really Ruled: A Political History of the Mongolian People's Republic, 1900-1978 (Histories of ruling Communist parties)*, Stanford: Hoover Institution Press, 1979; Rupen, R., *The Mongols of the Twentieth Century*, Bloomington: Indiana University Publications, 1964.

⁷ Lattimore, O., *Inner Asian Frontiers of China*. Boston: Beacon Press, 1962; Lattimore, O., *Nomads and Commissars; Mongolia Revisited*. New York: Oxford University Press, 1962.

⁸ Баврин, Е. П., Мещеряков, М. В., *Монгольская Народная Республика* (Экономика и внешняя торговля), Москва, 1961.

⁹ Якимова Т.А., *Монгольская Народная Республика*. Экономика и внешняя торговля. Москва: Внешторгиздат, 1959 /1955?/.

¹⁰ *БНМАУ социалист орнуудын эдийн засгийн түүх*, Улаанбаатар: Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар, 1984.

3. Худалдааны товч тойм

1949-1960 оны Хятадын гадаад бодлогыг Хятадын түүхэнд “Нэг талд налах бодлого” гэж нэрлэдэг. Дэлхийн хоёр туйлт систем, ид өрнөж байсан хүйтэн дайны улмаас шинэ байгуулагдсан БНХАУ 1960 оныг хүртэл Зөвлөлтийг налах бодлого явуулав. Ялангуяа 1956-1960 онд ЗХУ, БНХАУ, БНАГАУ зэрэг улсуудтай тогтоосон Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа эрчимтэй өсч, зөвхөн Зөвлөлттэй хийсэн худалдаа нь 1.3-1.8 тэрбум рубль болж, Хятадын нийт гадаад худалдааны эргэлтийн 50 хувьд хүрчээ. Энэ нөхцөл байдал нь Монгол-Хятадын худалдаа хөгжих таатай нөхцөл болов.

Монгол-Хятадын худалдааны харилцааг зохицуулсан эрх зүйн үндсэн баримт бичгүүд нь:

- 1952 онд байгуулсан “БНМАУ-БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр”,
- 1953 онд байгуулсан “БНМАУ-БНХАУ-ын бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр”,

1960 онд байгуулсан “БНМАУ-БНХАУ хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ” байв.

Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээрүүдийн үндсэн дээр 1953 оноос эхлэн БНМАУ-ын Гадаад Худалдааны Яам, БНХАУ-ын Гадаад худалдааны яам хооронд жил бүр “Харилцан бараа нийлүүлэх гэрээ” байгуулж, жил тутмын нийлүүлэх барааны тоо хэмжээ, үнэ, чанар, хугацааг тохирч байв. Жил бүрийн “Харилцан бараа нийлүүлэх гэрээний” хүрээнд Бээжинд очсон Монголын худалдааны төлөөлөгчид Хятадын компаниудтай, Улаанбаатарт ирсэн Хятадын худалдааны төлөөлөгчид Монголын Гадаад Худалдааны Яам ба Эд хэрэглэгчдийн Хоршоодын Төв Холбоотой бараа тус бүрээр гэрээ байгуулж, гэрээндээ тухайн барааг нийлүүлэх нарийвчилсан тодорхойлолтууд, техникийн шаардлага зэргийг тохирч байв.

Монголын талаас Гадаад Худалдааны Яам, Эд хэрэглэгчдийн хоршоо гэсэн хоёр байгууллага Хятадтай хийх худалдааг гардан гүйцэтгэж, Хятадад жил бүр 10-20 мянган адуу, ангийн үс, яс, хаягдал төмөр зэрэг түүхий эд нийлүүлдэг байв.

Хятадын талаас БНМАУ-тай дараах төрийн өмчит компаниуд худалдаа хийж байв.

- Мал аж ахуйн бүтээгдэхүүний барааны компани. Тус компани нь 1951-61 онд “China National Animal Products Corporation”, 1961-70 онд “China

National Animal By-Products Import and Export Company” хэмээн нэрлэгдэж байв. 1950-65 онд Монголоос жил бүр 10-30 мянган адуу болон малын түүхий эд, ангийн үс худалдан авч байв.

- Цайны компани. 1949 оны 11 сард байгуулагдсан, БНХАУ-ын хамгийн анхны улсын хэмжээний компани. Монголд цай болон тамхи нийлүүлж байв.
- Үр тариа тос ба хүнсний компани. 1953-1961 онд “China National Cereals, Oils and Oilseeds Export Corporation”, 1961-65 онд “China National Cereals, Oils and Foodstuffs Import and Export Corporation” хэмээн нэрлэгдэж байсан. Монголд гурил, будаа болон хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж байв.
- Орон нутгийн үйлдвэрийн барааны компани. 1953-61 онд “China National Native Products Export Company”, харин 1961-70 онд Цайны компанитай нэгдэж “China Tea and Native Product Import and Export Company” гэж нэрлэгдэж байв. Бараа гүйлгээ нь 700-800 сая юань болдог ба тамхи, нэхмэлийн утас, хятад эмийн зүйл, орон нутгийн үйлдвэрийн бараа, гар урлалын зүйл, зөгийн бал, хатаасан жимс зэрэг барааг гадаадад гаргадаг. Гар урлалын бараа болон дүнсэн тамхи, чавга зэрэг барааг Монголд нийлүүлж байв. Тус компани нь БНМАУ-д 1959 оны байдлаар 2.5 сая рублийн зүйл нийлүүлжээ.¹¹
- Төрөл бүрийн барааны компани. Тус компани нь жилдээ 150 сая рублийн барааг экспортолдог ба үүнээс ЗХУ 75 хувийг, БНМАУ-д 2 хувийг гаргадаг байв.¹²
- Металл импорт компани. Монголоос хаягдал төмөр импортлон авч байв. 1958 оны байдлаар тус компани Монголоос 4.3 мянган тн хаягдал төмөр худалдан авчээ.

Мөн эдгээрээс гадна дараах нэр бүхий компаниудтай худалдаа хийжээ.

- Хятадын импорт-экспортын компани
- Гадаад худалдааны тээврийн компани
- Хөнгөн үйлдвэрийн компани
- Химийн барааны компани
- Торгоны компани
- Нэхмэл барааны компани

¹¹ МУҮТА, ф-38, д-1, хн-50, 243-244-р тал.

¹² МУҮТА, ф-38, д-1, хн-50, 251-252-р тал.

- Машины компани (中国第一汽车制造厂 буюу FAW)

Эдгээр компаниудаас гадна бага хэмжээний худалдаа хийсэн бусад компаниуд бий. Хятадын эдгээр төрийн өмчит компаниуд зах, зээлийн нөхцөлд шинэчлэгдэн зохион байгуулагдсан хэлбэрээр өнөөдөр ч үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд төрийн өмчит SOFCO компаний бүтэц, бүрэлдэхүүнд харъяалагдаж байна.

Хятадаас БНМАУ-д бөс даавуу, гурил, цагаан будаа, цай, тамхи, жимс зэрэг өргөн хэрэглээний бараа импортлон авч байв.

Монгол-Хятадын худалдаанд 1950-1960 онд ЗХУ-ын рублийн хуучин ханш, 1961 оноос хойш түүнийг 4.4 дахин чангаруулсан шинэ ханш үйлчилж байв. Тус өгүүлэлд Монгол-Хятадын худалдааны дүн мэдээг 1961 оны Зөвлөлтийн рублиэр илэрхийлэв. 1950-1960 оны тоо, баримтуудыг 1961 оноос хойшхи ЗХУ-ын шинэ рублид 4.4х1 харьцаагаар шилжүүлэв. Америк доллараар илэрхийлсэн мэдээллийг ЗХУ-ын 1961 оны рублийн ханшид шилжүүлэхдээ ОХУ-ын Төв Банкны вэб сайтад буй ЗХУ-ын рублийн 1924-1992 оны албан ёсны ханшийн мэдээнд үзүүлсний дагуу¹³ 1 рублийг 0.9 америк доллартай тэнцүү гэж тооцов.

4. Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт

Монгол-Хятадын 1950-60-аад оны худалдааны дүн мэдээг тус хоёр улс тус тусдаа нэгтгэн гаргаж байсан бөгөөд энэ тухай Л.Бэгзжавын “Монгол-Хятадын харилцаа, 1949-1999” судалгааны бүтээл¹⁴, “Хятадын гадаад эдийн засаг, худалдааны жилийн танилцуулга: 1984” статистикийн эмхтгэл¹⁵ бүтээлүүдээс үзэж болно. Мөн түүнчлэн МУУТА-т хадгалагдаж буй БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны “БНМАУ-БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн харилцааны тухай илтгэл, танилцуулга” нь тус хоёр улсын худалдааны тухай тухайн цаг үед бичигдсэн албан ёсны эх сурвалж юм¹⁶.

¹³ ОХУ-ын Төв Банкны вэб сайт, “Курсы валют за период до 01.07.1992”, http://cbr.ru/currency_base/OldDataFiles/USD.xls

¹⁴ Л.Бэгзжав, *Монгол-Хятадын харилцаа (1949-1999)*, Улаанбаатар, 1999, 36, 66-р тал.

¹⁵ 中国对外经济贸易年鉴1984, 北京: 中国对外经济贸易出版社, 1984年, IV-22页。

¹⁶ МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-9-р хуудас.

Монгол-Хятадын худалдааны эргэлт.

1950-1965 он, сая рубль. 1-р хүснэгт

Он	Монгол-Хятадын худалдаа*			Монгол-Хятадын худалдаа**			Монгол-Хятадын худалдаа***		
	Нийт эргэлт	Монголын импорт	Монголын экспорт	Нийт эргэлт	Монголын импорт	Монголын экспорт	Нийт эргэлт	Монголын импорт	Монголын экспорт
1950									
1951				0.83	0.83	-			
1952	0.5			0.31	-	0.31	1.4	0.7	0.7
1953	1.7			2.14	0.32	1.82	2.6	1.1	1.5
1954	3.6			3.36	2.31	1.04	2.4	1.6	0.8
1955				4.68	2.67	2.01	3.6	2.0	1.6
1956	9.5			12.03	7.83	4.20	9.4	6.2	3.2
1957	15.2	4.0	11.2	27.01	22.26	4.76	14.2	10.2	4.0
1958				46.26	43.03	3.22	16.5	14.1	2.4
1959				49.27	45.96	3.31	21.9	19.2	2.7
1960	22.9	2.9	19.2	49.49	45.91	3.58	27.4	24.5	2.9
1961	25.2	3.8	21.4	55.49	50.92	4.57	24.1	20.3	3.7
1962	20.7	5.6	15.1	29.84	23.04	6.80	17.1	11.3	5.8
1963	13.6	6.3	7.3	29.83	22.00	7.83	14.0	7.9	6.3
1964	3.2	0.3	2.9	11.99	11.52	0.47	3.1	2.8	0.3
1965	4.8	3.1	1.7	12.99	8.46	4.53	5.2	1.6	3.6
1966	2.0	1.0	1.0	3.11	2.10	1.01	2.4	1.6	0.8
1967	0.3	0.2	0.1	0.39	0.19	0.20	0.4	0.2	0.2

* Эх сурвалж: Л.Бэгзжав, Монгол-Хятадын харилцаа (1949-1999), Улаанбаатар, 1999, 36, 66-р тал.

** Эх сурвалж: 中国对外经济贸易年鉴1984, 北京: 中国对外经济贸易出版社, 1984年, IV-22 页.

*** Эх сурвалж: Дугаржав, БНМАУ-БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцааны тухай илтгэл, танилцуулга, БНМАУ-ын Гадаад Худалдааны Яам, 1968 оны 5 сарын 20. МУУТА, ф-38, д-1, хн 917, 1-9-р хуудас.

Дээрх хүснэгтээс үзэхэд Монгол-Хятадын худалдааны тухай тоо баримтуудын хооронд их хэмжээний зөрүү гарч байна. Тухайлбал, 1960 оны Монгол-Хятадын худалдааны нийт эргэлтийг Л.Бэгзжав 22.9 сая рубль, Хятадын гадаад худалдааны статистикт 49.49 сая рубль гэсэн бол БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны 1968 оны танилцуулгад 27.4 сая рубль гэж тэмдэглэсэн байна. Худалдааны нийт эргэлтийн хувьд Л.Бэгзжав болон БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны илтгэлийн дүн мэдээ хоорондоо ойролцоо байгаа бол харин БНХАУ-ын статистик мэдээн дэх 1957-65 оны хоорондох дүн мэдээ Монголын талын мэдээнээс 20 сая хүртэл рублиэр зөржээ. Энэ зөрүү нь Хятадаас авсан Монголын импортын дүн мэдээ их хэмжээгээр зөрснөөс үүссэн бөгөөд харин Монголоос Хятадад гаргасан


экспортын хувьд дүн мэдээнүүд их зөрүүгүй байна. Юутай ч, бидний хувьд хүснэгтэд оруулсан гурав дахь баримт болох БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамнаас 1968 оны 5 сарын 20-нд нууцын зэрэглэлтэйгээр гаргасан “БНМАУ-БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцааны тухай илтгэл, танилцуулга” хэмээх судалгаанд буй тоог албан ёсны эх сурвалж хэмээн үзэж цаашид баримтлах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

5. Харьцуулалт ба онцлог

1950-1965 оны Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт, экспорт, импортыг дээр дурдсан Гадаад Худалдааны Яамны илтгэлд үндэслэн графикаар үзүүлвэл дараах өсөлт, бууралт харагдана (1950-51 оны худалдааны тооцоо 1952 оны дүн багтсан).

1-р график

Монгол-Хятадын худалдааны эргэлт, 1950-1965 он
сая рублиэр




Эх сурвалж: Дугаржав, БНМАУ-БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцааны тухай илтгэл, танилцуулга, БНМАУ-ын Гадаад Худалдааны Яам, 1968 оны 5 сарын 20.

МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-9-р хуудас.

Энэ үед Зөвлөлт-Хятадын худалдааны нийт хэмжээ 500-1800 сая рубль байсан бөгөөд Монгол-Хятадын худалдааны өсөлт, бууралтын муруйг Зөвлөлт-Хятадын худалдаатай харьцуулъя. Ингэхдээ тоон утгыг харьцуулахгүй, харин өсөлт, бууралт, нийт эргэлтийн өөрчлөлтийг анхаарна.

Зөвлөлт-Хятадын худалдааны эргэлт, 1950-1965 он
сая рублиэр



Эх сурвалж: Внешняя торговля СССР. Статистический сборник. 1918-1966. Москва. 1967, 66-67-р тал.

Графикаас харахад Монгол, Хятад хоёр хөрш орны харилцааны онцлог байдал тодорхой харагдаж байна. Үүнд:

А. Худалдааны нийт эргэлтийн тухайд:

- Монгол-Хятадын социалист худалдаанд 1950-1955 оны сэргэлт, 1956-1960 оны өсөлт, 1961-1965 оны бууралт гэсэн гурван үе шат байгаа бол харин Зөвлөлт-Хятадын худалдааны муруйнд 1957 оны огцом бууралтыг эс тооцвол 1950-59 оны өсөлтийн үе, 1960-65 оны бууралтын үе гэсэн хоёр үе харагдана.
- 1950-51 оноос эхэлсэн Зөвлөлт-Хятадын худалдааны хурдацтай өсөлтөөс Монгол-Хятадын худалдааны өсөлт даруй 5 жилээр хоцорч, 1956 оноос эрчимтэй өсч эхэлсэн байна.
- Зөвлөлт-Хятадын худалдааны эргэлт 1960 оноос эхлэн зогсолтгүй буурч, улмаар 1965 онд 1959 оныхоос тав дахин багассан бол Монгол-Хятадын худалдааны эргэлт 1961 оноос эхлэн буурсаар 1964 онд 1960 оныхоос ес дахин багассан ба ба богино хугацаанд Зөвлөлтийнхөөс огцом хорогдсон байна.

Б. Монголын экспорт:

1. Хугацааны ихэнхэд Монголын экспорт 1-4 сая рублийн хооронд хэлбэлзэж ирсэн, хугацааны сүүл үед эрчимтэй өсч 5.8-6.3 сая рубль болоод эргээд

унасан муруй харагдаж байна. Харин Зөвлөлтөөс Хятадад хийсэн экспорт нь 1950-56 оны өсөлт, тогтворжилт, 1957 оны огцом уналт, 1958-59 оны сэргэлт, 1960 оноос хойшхи уналт бүхий бөгөөд Монголоос Хятадад хийсэн экспортын муруй нь Зөвлөлтөөс Хятадад хийсэн экспортын муруйтай харьцуулахад огт өөр байна.

В. Монголын импортын тухайд Хятадаас Монголд авсан импортын муруй ба Зөвлөлтөд Хятадаас авсан импортын муруй ерөнхийдөө төстэй байна. Гэхдээ хоёр ялгаа байгаа нь:

1. Зөвлөлтөд Хятадаас авсан импортын өсөлт 1950-51 оноос эрчимтэй өсч эхэлсэн байгаа бол Монголд Хятадаас авсан импорт 1955 оныг хүртэл бага хэмжээнд тогтвортой байгаад 1955 оноос эрс өсч эхэлсэн байна.
2. Монголын импорт нь экспортоосоо найм дахин өндөр байгаа нь харьцангуй балансаа барьдаг Зөвлөлт-Хятадын худалдаанаас огт өөр байна.

Г. Худалдааны тэнцлийн тухайд:

1. Зөвлөлт-Хятадын худалдаанд Зөвлөлтийн экспорт давамгайлсан үе, Зөвлөлтийн импорт давамгайлсан үе гэсэн хоёр үе байгаа ба эдгээрийн зааг хязгаар нь 1956 он байна. Харин Монгол-Хятадын худалдаанд хугацааны ихэнхэд Монголын импорт экспортоосоо давж байна.
2. Хугацааны турш Зөвлөлт-Хятадын экспорт, импортын хэмжээ ямагт ойролцоо явж ирсэн бол Монгол-Хятадын худалдаанд 1956-62 оны хооронд Хятадаас авсан Монголын импорт нь экспортоосоо олон дахин их байна. Монгол-Хятадын худалдаа нь Монголд Хятадаас авсан импорт үнэмлэхүй давамгайлсан худалдаа байснаараа Хятад-Оросын худалдаанаас ялгарч байна.

Энэхүү харьцуулалтын дундаас урьд өмнөх судалгаанд орхигдож ирсэн дараах хоёр өсөлтийн шалтгааныг авч үзье.

1. 1956-1960 онд Зөвлөлт-Хятадын импорт, экспорт ойролцоо байсан бол Монгол-Хятадын худалдаанд Монголын импорт огцом өсч, худалдааны нийт эргэлт түүнийг даган нэмэгджээ.
2. 1961-1963 онд Зөвлөлтөөс Хятадад гаргах экспорт буурч байсан бол Монголын экспорт эсрэг чиглэлд эрчимтэй өсчээ.

6. Импорт давамгайлсан шалтгаан

1956 оны 1 сарын 1-нд Улаанбаатар-Жининий төмөр зам нээгдэн тус хоёр улс анх удаа төмөр замаар холбогдож, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу жил бүр 12 мянган ажиллах хүч Хятадаас Монголд ажиллах болж, БНХАУ-аас БНМАУ-д 1956, 1958, 1960 онуудад 36 сая рублийн буцалтгүй тусламж, 67.5 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгож, Зөвлөлт-Хятадын худалдааны идэвхжлийг даган өссөн транзит тээврийн төлбөрөөр монголчууд Хятадаас их хэмжээний өргөн хэрэглээний бараа импортлон авах болов.

1956-60 онд Монгол-Хятадын худалдааны эргэлт 9.4-27.4 сая рубль болж нэмэгдсэн бөгөөд 1955 онтой харьцуулахад 1960 онд худалдааны эргэлт 8 дахин өсчээ. Монголд Хятадаас оруулсан импорт төмөр зам тавихаас өмнөх үеэс 12 дахин өсч 24.5 сая рубль болсон нь худалдааны нийт эргэлт өсөх шалтгаан болжээ. Харин энэ хугацаанд Монголоос Хятадад гаргасан экспорт 2.4-4 сая рублийн хооронд байсан ба өмнөх үетэй ойролцоо байв.

Монголын импортын энэхүү огцом өсөлт нь Хятадаас Монголд төлж байсан транзит тээврийн төлбөртэй холбоотой юм. Транзит тээврийн төлбөр гэж БНХАУ өөрийн бараагаа Монголын төмөр замаар дамжуулан ЗХУ болон бусад улс руу тээвэрлэсний хөлсөнд Улаанбаатар төмөр зам ХНН-д төлөх төлбөрийг хэлнэ.


1956 онд ашиглалтанд орсон Улаанбаатар-Жининий төмөр зам Хятадыг Монголын нутгаар дайруулан Зөвлөлт болон Дорнод Европын орнуудтай холбосон дөт зам болов. 1956 онд БНХАУ-аас Монголын төмөр замаар дамжуулан ЗХУ болон Дорнод Европын орнууд руу ачаа тээвэрлэсний хөлсөнд БНМАУ-д 7.2 сая рубль төлөх байв. Монголын тал 1956 онд Хятадын талд 2.2 сая рублийн бараа нийлүүлж, Хятадаас мөн 2.2 сая рублийн бараа авахаар төлөвлөөд байжээ. 1956 оны худалдааны хэлэлцээрийн үеэр Хятадын тал транзит тээврийн төлбөр 7.2 сая рублийг Монголын талд бараа нийлүүлэх журмаар төлөх санал гаргав.¹⁷ Ингээд уг саналыг Монголын худалдааны төлөөлөгчид зөвшөөрөн үзэж, Хятадын талаас 3 сая рублийн бараа нэмж авахаар захиалснаар 1956 оны Хятадаас авах Монголын нийт барааны мөнгөн дүн анх удаа 6.2 сая рубль болж өсчээ.

1956-60 онд Хятадаас авч байсан бараа, бүтээгдэхүүний ихэнх хувийн төлбөрт транзит тээврийн төлбөрийг орлуулан тооцсоноор Монголд Хятадаас оруулах импорт хурдацтай нэмэгдэж, худалдааны нийт эргэлт 1960 онд 27.4 сая рубль болох гол нөхцөл болжээ. Ингэснээр транзит тээврийн төлбөрөөс Монгол-Хятадын худалдаанд эзлэх хувь маш их хэмжээнд хүрэв. Үүнийг транзит тээврийн

¹⁷ МУҮТА, ф-11, д-2, хн-218, 118-р хуудас.

төлбөрийн хэмжээ ба түүний Монголын импортод эзлэх хувийг харуулсан доорх графикаас харж болно.

3-р график



*Эх сурвалж: БНМАУ-БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцааны тухай илтгэл, БНМАУ-ын Гадаад Худалдааны Яам, 1968 оны 5 сарын 20.

**МУҮТА, ф-38, д-1, хн-917, 1-9-р хуудас.

Транзит тээврийн төлбөр нь 1956-1960 онд дунджаар 3-18 сая рублийн хооронд хэлбэлзэж байсан ба уг төлбөрөөр Монголын Хятадаас авсан барааны 89 хүртэл хувийг төлж байв. Иймээс Монгол-Хятадын худалдаа Монголын нутгаар дамжих Зөвлөлт-Хятадын хоорондын тээврийн хэмжээтэй шууд хамааралтай болон хувирчээ. Ийнхүү Монгол-Зөвлөлтийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үндсэн дээр БНХАУ-ын ачааг Монголын нутгаар тээвэрлэсний хөлсөнд Улаанбаатар төмөр зам ХНН-д төлөх БНХАУ-ын төлбөрийн Монголын талд оногдох хувийг Монгол-Хятадын худалдаанд оруулан тооцох болсноор Монголд Хятадаас авах импорт өмнөх үеэс олон дахин нэмэгдэж, 1960 он гэхэд монголчуудын өдөр тутмын ахуйн хэрэглээнд хятад бараа ихээр нэвтэрч, Хятадын эдийн засгийн нөлөө Монголд өсөн нэмэгдэж байв.

7. 1960-1963 оны Монголын экспортын өсөлт

1958 оны олон улсын коммунист, ажилчны намуудын Москвагийн зөвлөгөөнөөс эхлэн зэвсэг нэгт ахан дүүсийн зөрчил ил болсон билээ. 1960 онд Румыны коммунист намын их хурал дээр МАХН-ын төлөөлөгчид анх удаа

ХКН-ын бодлогыг шүүмжилсэн үг хэлсэн нь ЗХУ, БНХАУ-ын маргаанд БНМАУ татагдан орох эхлэлийг тавив. 1963 оны 12-р сарын 22-нд МАХН-ын Төв Хороо ХКН-ын 5-р бүгд хурлаас “ХКН-ын удирдагчдаас дэлхийн коммунист хөдөлгөөнд гаргаж байгаа зөрөлдөөн ба МАХН-ын бодлогын тухай” тогтоол гаргав. Тогтоолд: “ХКН-ын удирдлага марксизм-ленинизмээс ухарч, марксизм-ленинизмд харш үзэл санаагаа дэлхийн коммунист хөдөлгөөнд тулган хүлээлгэх, бусад коммунист нам, социалист орнуудыг эрх зоргондоо оруулан захирах гэж элдвээр оролдож байна” хэмээн шүүмжлэв.¹⁸

Зөвлөлт-Хятадын маргаантай холбоотойгоор Хятадын “нэг талд налах бодлого” 1960 оноос өөрчлөгдөн өөрийн хүчинд тулгуурлах арга замд шилжиж, БНХАУ социалист блокын орнуудаас гадна чөлөөт ертөнцийн улсуудтай хийх худалдаагаа нэмэгдүүлж, социалист орнуудтай хийх худалдааны балансыг тэнцүүлж алдагдалгүй болох буюу Зөвлөлтийн талыг баримтлагч социалист орнуудтай хийх худалдаагаа шууд хорогдуулж эхлэв. 1960 онд ЗХУ-ын зүгээс БНХАУ-д ажиллаж байсан мэргэжилтнүүдээ татаж, мөн оноос эхлэн Зөвлөлт-Хятадын худалдаа, зээл тусламжийн харилцаа эрс хорогдож, 1965 он гэхэд 375 сая рубль болтлоо буурчээ.

Иймээс 1960 оноос эхлэн Монголын нутгаар дамжуулан тээвэрлэх Хятадын ба Зөвлөлтийн төмөр замын ачаа тээвэр багасч, Монголын транзит тээврийн орлого 1960 онд 18 сая рубль байсан бол 1961 онд 9.7 сая, 1962 онд 9.8 сая, 1963 онд 4.2 сая, 1964 онд 1.5 сая гэх зэргээр буурсаар 1965 онд 400 мянган рубль болов. Транзит тээврийн төлбөр нь Монголд Хятадаас оруулдаг импортын 50-80 хувийг эзэлж байсан бол 1961-65 онд энэ хэмжээ 25 хувь болтлоо буурчээ. Энэ нь Хятадаас импортлон авдаг барааныхаа 50-80 хувийг транзит тээврийн төлбөрөөр төлдөг Монголын хувьд их хэмжээний хорогдол байв.

1960 оны байдлаар Монголын тал Хятадад нийлүүлж байгаагаасаа их зүйл, ялангуяа иргэдийн өргөн хэрэглээний барааг их хэмжээгээр Хятадаас худалдан авч, энэхүү гадаад худалдааны алдагдлыг транзитын төлбөрөөр барагдуулж байсан бол 1961 оноос транзитын төлбөр хоёр дахин буурч, цаашид ч буурснаар энэхүү гадаад худалдааны алдагдлыг нөхөх зүйлгүй болов.

Зөвлөлт-Хятадын маргаанд БНМАУ Зөвлөлтийн талыг тууштай баримтлах нь 1960 оноос хойш нэгэнт ойлгомжтой болсон тул БНХАУ-ын зүгээс БНМАУ-тай хийх худалдаандаа экспорт, импортыг тэнцүүлэх бодлого баримтлах болов. Монгол-Хятадын жил бүрийн харилцан бараа нийлүүлэх хэлэлцээр дээр хэлэлцдэг

¹⁸ “Үнэн”, 1964.06.13. № 165 (9064).

гол зүйл нь Монголын талын экспортыг нэмэгдүүлэх, Монголын импортыг хорогдуулах замаар экспорт, импортыг ойртуулах явдал болон хувирав.Транзит тээврийн төлбөр багассан нөхцөл байдалд явуулсан Хятадын энэхүү бодлогын улмаас Хятадаас авах Монголын импортын бараа эрс багасч, 1960 онд 27 сая рублийн бараа Хятадаас импортолсон бол 1961 онд 20.3 сая, 1962 онд 11.3 сая, 1963 онд 7.9 сая, 1964 онд 2.8 сая, 1965 онд 1.6 сая рубль болжээ.

Монголын хувьд Хятадтай хийх худалдааны харилцааг хэвээр хадгалахыг эрмэлзэж байв. Хятадаас гадаад худалдаандаа баланс тэнцүүлэх бодлого явуулж буй нөхцөлд Монголын тал Хятадтай худалдааны харилцаагаа хадгалж үлдэхийн тулд экспортоо нэмэгдүүлэх шаардлагатай байв. Үүнийг Хятадын тал ч шаардах болжээ.Тухайлбал, 1963 оны худалдааны хэлэлцээрийн үеэр Хятадын тал Монголын экспортыг адуу 20 мянга, цөцгийн тос 200 тн, халуун угаалгын ноос 300 тн, ноолуур 50 тн, тэмээний ноос 100 тн, өөхөн тос 1000 тн, мах амьдын жингээр 1,500 тн, адууны шир 20 м.ш., үхрийн шир 30 м.ш., унаганы арьс 2 м.ш., хуучин дугуй 1,000 тн, адууны сүүл 30 тн зэрэг бараанаар нэмэгдүүлж өгөхийг хүсчээ. Монголын тал энэ хүсэлтийг судлан үзээд адуу 20 мянган толгой, цөцгийн тос 100 тн, хуучин дугуй 200 тн, адууны сүүл 20 тн-ыг нэмэгдүүлж¹⁹, улмаар Монголоос Хятадад гаргасан экспорт 1963 онд 6.3 сая рубль болж, хугацааны хамгийн өндөр хэмжээндээ хүрчээ. Хятадын зүгээс 1963 онд энэхүү 6.3 сая рубльд тааруулж Монголд 7.9 сая рублийн бараа өгчээ.Гэвч Монголын эдийн засагт экспортыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх нөөц боломж байсангүй учраас1964 онд Монголоос Хятадад ердөө 0.3 сая рублийн бараа экспортолжээ.

Ийнхүү Зөвлөлт-Хятадын маргааны дунд оршиж байсан БНМАУ Хятадтай харилцах тухайд ялангуяа худалдааны талаар Зөвлөлтөөс ялгаатай, бие даасан бодлого явуулжээ. Энэ бол экспортыг нэмэгдүүлж, хоёр улсын худалдааны харилцааг хадгалж үзэхийг эрмэлзсэн бодлого байв. Гэвч социалист улсуудын хоорондын бүх төрлийн харилцааг коммунист намууд, ялангуяа ЗХУКН удирдан хянаж зохицуулж байсан нөхцөлд Монгол-Хятадын харилцаа цаашид амжилттай хөгжих боломж байсангүй.

8. Дүгнэлт

Зөвлөлт-Хятадын найрамдал ба харилцааны хүйтрэл нь 1950-1965 оны Монгол-Хятадын худалдааны огцом өсөлт, бууралтад нөлөөлөхдөө Монголын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн төлбөрөөр дамжиннөлөөлсөн

¹⁹ МУУТА, ф-38, д-1, хн-389, 35-р хуудас

байна. Зөвлөлт-Хятадын харилцаа сайн байх үед Монголын төмөр замаар дамжих Хятадын бараа тээвэр нэмэгдэж, түүнийг даган Хятадаас Монголд төлөх транзит тээврийн төлбөр өсч, Монгол-Хятадын худалдаа огцом нэмэгдэж байжээ. Харин Зөвлөлт-Хятадын харилцаа хүйтэрч, Монголын нутгаар дамжин өнгөрөх Хятадын бараа багасмагц Монгол-Хятадын худалдаа огцом унажээ. Иймээс транзит тээврийн төлбөр нь Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны хөгжилд Хятадаас Монголд үзүүлсэн зээл, тусламж, ажиллах хүчний туслалцаатай адил хэмжээнд үнэлэгдэхүйц чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Зөвлөлт-Хятадын маргааны үед БНМАУ-ын эрх баригчид МАХН-ын зүгээс Зөвлөлтийн талыг тууштай баримталж байсан ч Хятадтай харилцаагаа хадгалж үлдэхийг эрмэлзэж, худалдаагаа идэвхжүүлэх зорилт тавьж байсан явдал Монголын экспортын өсөлтөөс тодорхой харагдаж байна. Энэ бол хүйтэн дайны үед Хятадаас жижиг социалист орнуудад хандан явуулсан бодлого ба Монголоос өмнөд их хөрштэйгээ найрамдлыг эрхэмлэн харилцах бодлогыг тодруулан үзэх чухал баримт юм.

Abstract: This article describes the socialist trade between Mongolia and China in 1950-65. The main data source is from the Report of Foreign Trade Ministry of Mongolian Peoples Republic. In 1950-65, Mongolian-Chinese trade developed by three stages. In the most successful years, 1956-60, Mongolian-Chinese trade is based on Chinese payment of transit railway to Mongolia. Greater part of Mongolian-Chinese trade was Mongolian import from China. Since 1961, the Mongolian-Chinese trade is based on Chinese policy to ecuate trade balance and on Mongolian policy to hold trade relation with China.